

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН “ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.10.07

Мандалговь хот

№	Бодлогын баримт бичгийн холбогдох заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт			Төсөв /сая төг/	Хэрэгжилт	Хувь
				Суурь түвшин	Зорилт од түвшин			
Боловсролын салбарын боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр								
1	Аймгийн стратеги төлөвлөгөөний 9.3.2.1	Боловсролын салбарын багш нарын ар гэрийг судалж, судалгаанд үндэслэн өрхийн орлогыг дээшлүүлэх боломж нөхцөлийг тооцоолж салбар дундын байгууллагуудтай хамтран ажилд зуучлах	Салбар дундын байгууллагуудтай хамтран ажилд зуучилсан хүний тоо	шинээр	20	-	Боловсролын салбарын багш нарын ар гэрийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргаж Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүллээ.	100
2		Боловсролын салбарын багш ажилчдын ёс зүй, манлайллын бүсчилсэн сургалт зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан хүний тоо	2017 он 400	400	УТ 5.0	Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч, аймгийн ёс зүйн зөвлөлийн гишүүн С.Алимаа 22 цэцэрлэгийн давхардсан тоогоор 1391 багш ажилчдад ёс зүйн 18 удаагийн сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан. “Ёс зүйн жил-2022” аяны хүрээнд 2168 төрийн албан хаагч болон төрийн үйлчилгээний албан хаагчдад цуврал сургалт зохион байгуулан ажилласан. Тус сургалтын үр дүнд багш ажилчдаас ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол гараагүй.	70
3		Аймгийн хэмжээнд хүүхдийн хүмүүжил төлөвшилтэй холбоотой уриалгыг гарган эцэг эх асран хамгаалагч, иргэд, төрийн болон төрийн бус	Хамтран ажилласан хүний тоо	шинээр	200 эцэг эх асран хамгаалагч	УТ ОНТ 7.7	Хүмүүжлийн эерэг арга модуль сургалтын хүрээнд “Эерэг аргаар харилцах” сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулж 15 сумын 866 багш ажилтан, 2848 эцэг эх хамрагдаж 189 сурагч “Гар утасны зөв зохистой хэрэглээ”, “хорт зуршлаас татгалзах”, “сөрөг зан үйлээ өөрчлөх”	100

		байгууллагуудтай хамтран ажиллах.					зэрэг өөрийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан. Мөн дээрэлхэл, үе тэнгийн дарамт, хувийн онцлог сэдвээр сургалтад 4955 хүүхдийг хамруулав	
4	Аймгийн Засаг даргын 2022 оны 01 захирамжийн хүрээнд	Иргэдийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх үе шаттай сургалтуудыг явуулах	Суралцсан хүний тоо	-	20	5 сая	Боловсролын судалгааны Үндэсний Хүрээлэнгээс зарласан Welcome хөтөлбөрийн шалгаруулалтад 2 сургууль материал хүргүүлснээс ЭДЦС тэнцэж 10 сарын 10 аас 2023 оны 5 сарын 10 хүртэл англи хэлний сургалтыг ахлах ангийн хүүхдүүдэд зохион байгуулахаар болсон	30
5		Багш нарт цахим хичээл боловсруулах мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Суралцсан хүний тоо	-	100	5 сая	Дундговь аймгийн 19 сургуулийн 103 багш эрдмийн далай цогцолбор сургууль дээр 04 сарын 20-21-ний өдрүүдэд medle.mn цахим платформ дээр “Ээлжит хичээлийн цахим контент” байршуулах, хичээл байршуулахад тавигдах шаардлага, цахим хичээл бэлтгэхэд шаардлагатай програм хангамжийн сургалтыг Боловсролын мэдээллийн технологийн зөвлөх багш Я.Отгонбат, Б.Лхагвамаа, М.Цогбаяр багш нар ирж Дундговь аймагт хуваарилагдсан бага ангийн монгол хэл, математик хүн байгаль, ёс зүй, бүрэн дунд боловсролын үндэсний бичиг, түүх хичээлийн 227 ээлжит хичээлийн хуваарилалтыг танилцууллаа. Эрдэнэ далай суманд баруун бүсийн сумдын 200 багшид Монгол улсын гавъяат Ө.Цэндсүрэн багш ахлагчтай 13 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын баг ирж “Ээлжит хичээлийн цахим контентд суурилсан сургалтын агуулга ,аргазүйд багш бүтээлчээр суралцах нь” сургалт семинар 2 өдөр зохион байгуулагдаж судлагдахуун бүрийн багш нар баг болж хамтран ажиллалаа.	100
6	“Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн	Хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжлийн багшлах боловсон хүчний нөөцийг	- Хөдөө аж ахуйн мэргэжлийн багшийн тоог	3 багшийг ХАБЭА-н	2	5.0	Хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжлийн багшлах боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, багш нарыг мэргэшүүлж сургах зорилгоор Биологийн багш	100

	4.1.1 Орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг шинээр бэлтгэх	бүрдүүлэх, багш нарыг мэргэшүүлж сургах	нэмэгдүүлсэн байна - Багш нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулна. -Зарцуулагдсан төсөв	сургалт ад хамруулсан.			Ө.Дэлгэрмөрөн, Ойжуулагч мэргэжлийн багш Б.Адъяасүрэн нар Хөдөө, аж ахуйн Их сургуульд 2,5 жилээр суралцахаар элсээд байна. Тус 2 багш нь Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2021 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд засаг даргаас тус бүр 1.0 сая төгрөгийн төлбөрийн дэмжлэг авахаар материалын бүрдлийг ханган хүргүүлсэн. Мөн 9 дүгээр сард Малын бага эмч мэргэжлийн багш болон Зоотехникчийн мэргэжлийн багшийн сонгон шалгаруулалт зарлаж, мэргэжлийн ур чадвар, шаардлагыг хангасан нэг багшийг Малын бага мэргэжлийн багшийн орон тоонд томилоод байна.	
7		Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх түр сургалт зохион байгуулах	1.Сургалтад хамрагдсан хүний тоо	-	100	2.0	Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх мэргэшсэн жолооны түр сургалтыг 3,4 дүгээр сард 2 удаа зохион байгуулсан. Нийт 28 хүн хамрагдсан байна.	100
Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь								85.7%

ХЯНАСАН:

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГА

Ц.УРАНБЯМБА

ХЭРЭГЖИЛТ НЭТГЭСЭН:

СӨБ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.ОТГОНЖАРГАЛ